



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/152

Булган сум

**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл
ахуйн зөвлөл байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2025 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн, ажилтны эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтэн
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
	Нийгмийн даатгалын газрын дарга
	Эрүүл мэндийн газрын дарга
	Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
	Ажил олгогч эздийн холбооны тэргүүн
	Ажил олгогч эздийн холбооны тэргүүлэгч
	(зөвшилцсөнөөр)
	Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
	Үйлдвэрчний эвлэлийн хорооны тэргүүлэгч
	(зөвшилцсөнөөр)
Нарийн бичгийн дарга:	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010242

хариуцсан мэргэжилтэн

2.Зөвлөлийн дүрмээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд орон нутгийн онцлогт нийцүүлэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, зохион байгуулсан ажлын тайланг тухай бүрд нь хэлэлцүүлж ажиллахыг зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular stamp. The signature is stylized and appears to read 'Д.Пүрэв-Очир'. The stamp contains some faint, illegible text, possibly in Mongolian.

Д.ПҮРЭВ-ОЧИР